



***Монгол Улсын Улаанбаатар хот болон 21 аймгийн төвд Агаарын чанарын хяналтын автомат станц суурилуулах” төслийн хаалтын ажлыг 2026 оны 09 дүгээр сард зохион байгууллаа***

**Төслийн тухай:**

Монгол улсын БОУАӨЯ болон БНСУ-ын БОЯ болон байгаль орчны корпораци хоорондын гэрээ хэлэлцээрээр Улаанбаатар хот болон 21 аймгийн төвд мэдээллийн технологид суурилсан орчны агаарын чанарыг хянах автомат станцыг буцалтгүй тусламжаар суурилуулах төслийг 2023-2026 оны хооронд хэрэгжүүлж амжилттай дуусч байна. Энэхүү төслийн зорилго нь Монгол улсад агаарын чанарыг хянах автомат станцыг Улаанбаатар хот болон 21 аймгийн төвд суурилуулж, агаарын чанарын менежментийн чадавхыг сайжруулах юм.

**Төслийн үр дүнд:**

Улаанбаатар хот болон 21 аймгийн төвийн агаарын чанарыг хүхэрлэг хий, азотын ислүүд, PM<sub>2,5</sub> болон PM<sub>10</sub> тоосонцор, озон, нүүрстөрөгчийн дутуу исэл болон цаг уурын үзүүлэлтүүдээр хэмжиж иргэд олон нийтэд [agaar.gov.mn](http://agaar.gov.mn) платформаар мэдээллээ шууд дамжуулж байна. Мөн төслийн хүрээнд Агаар дахь хүхэрлэг хий, азотын ислүүд, озон, нүүрстөрөгчийн дутуу исэл, PM<sub>10</sub>, PM<sub>2,5</sub> тоосонцор болон цаг уурын үзүүлэлтүүдийг хэмжих хөдөлгөөнт лабораторийг Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторид хүлээлгэн өгч БНСУ-д 5 удаа нийт 80 орчим албан хаагч, УБ хотод 6 удаа давхардсан тоогоор 70 орчим албан хаагчийг, цахимаар 4 удаагийн сургалтад 90 орчим албан хаагчийг хамрууллаа. Мөн агаарын чанарын дүн мэдээг боловсруулах, үр дүнг үнэлэх, тайлан бичих MAMIS программыг хөгжүүлж дууссан.

Энэхүү төслийн хүрээнд Улаанбаатар хот болон 21 аймгийн төвийн агаарын чанарыг автоматаар тасралтгүй хэмжиж, улмаар агаарын чанарын мэдээг цахимаар харах боломж бүрдэж байна.

**Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж:**

Улсын сүлжээний газрын ахлах мэргэжилтэн: Т.Уянга

Холбогдох утас: 51-264251

Өрөөний дугаар: 804 тоот

email: [uyanga\\_t@namem.gov.mn](mailto:uyanga_t@namem.gov.mn)